



**НИЙСЛЭЛИЙН
СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын аварга
шалгаруулах “БОЧИ” тэмцээн зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах “БОЧИ” тэмцээнийг 2019 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Баянгол дүүргийн “Оюуны Ундраа” цогцолбор сургуулийн “А” зааланд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.230.000 /нэг сая хоёр зуун гучин мянган/ төгрөгийг Нийслэлийн спортын хорооны биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Л. Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг спортын хөгжлийн хэлтсийн дарга /С. Саранцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Спортын хорооны даргын
2019 оны *дөрөвдүгээр* сарын *10*-ны өдрийн
А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах
“БОЧИ” тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 1-р байр 20.000 x 7 = 140.000 төг 2-р байр 15.000 x 7 = 105.000 төг 3-р байр 10.000 x 7 = 70.000 төг	315.000
2.	Багийн шагнал:	150.000
3.	Шүүгчийн ажлын зардал: /5 хүн x 1 өдөр x 20.000 төг/	100.000
4.	Өргөмжлөл	35.000
5.	Анонс, цом	60.000
6.	Заал талбайн хөлс	300.000
7.	Тээвэр, зар сурталчилгаа, тайз	60.000
8.	Медаль 21 ширхэг x 10.000 = 210.000	210.000
ДҮН:		1.230.000

Нийслэлийн Спортын хорооны даргын
2019 оны *дөрөвдүгээр* сарын...-ны өдрийн
А.25 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Улаанбаатар хотын аварга
шалгаруулах "БОЧИ" тэмцээний
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------|-------------|
| 1. Ерөнхий шүүгч | Д.Бямбажав |
| 2. Шүүгч | Н.Алтанзул |
| 3. Шүүгч | Л.Очгэрэл |
| 4. Шүүгч | Ч.Баатархүү |
| 5. Шүүгч | М.Мөнхцэцэг |